

МУИС-ийн оюутан ёс суртахуунаараа манлайлна



ЁС ЗҮЙН АЯН

МУИС-ийн ШУС-ийн Хүмүүнлэгийн ухааны салбар

2022 он

МУИС-ийн ШУС-ийн Хүмүүнлэгийн ухааны салбар Дэлхийн ёс зүйн өдрийг тохиолдуулан оюутнууддаа **плагиризм буюу оюуны хулгайгаас** хэрхэн сэргийлэх талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх “Ёс зүйн аян”-ыг зохион байгуулж байна.

ОЮУНЫ ХУЛГАЙ ГЭЖ ЮУ ВЭ?

Бусдын санаа, бүтээлийг зөвшөөрөлгүй ашиглах, өөрийн юм шиг танилцуулахыг оюуны хулгай (plagiarism) гэнэ.

ОЮУНЫ ХУЛГАЙН ТӨРӨЛ

1. Санаатай үйлдсэн хулгай

Бусдын бүтээл, санааг зориуд өөрийн юм шиг танилцуулах аливаа үйлдэл нь оюуны хулгай мөн. Үүнд дараах тохиолдлууд багтана.

- Бусдын бүтээл, санаа, үг хэллэгийг эшлэл зүүлт хийлгүй хуулах
- Бусдын бүтээл, туурвилыг өөрийнх мэтээр танилцуулах
- Хамтран зохиогчдыг дурдалгүй бүтээлийг танилцуулах
- Бусдын бүтээл, судалгааны ажил (бие даалт, эсээ гэх мэт)-ын үр дүнг худалдаж авч, хулгайлж, зээлж өөрийн юм шиг танилцуулах, дамжуулах үед

2. Санамсаргүй үйлдсэн хулгай

Зохих мэдлэг, болгоомж, санамсаргүйгээр оюуны хулгай үйлдэгддэг. Үүнд дараах тохиолдлууд багтана.

- Эшлэл зүүлтийг зохих стандартын дагуу хийгээгүй байх
- Ашигласан эх сурвалжийн үндсэн агуулгыг өөрчлөхгүйгээр найруулан бичих
- Бусдын дэвшүүлсэн үзэл санаа, онол сэтгэлгээг тодорхой эшлэл зүүлт авалгүй нэмж хөгжүүлэх

3. Өөрийн хулгай

Урьд нь бичсэн бүтээл, судалгааныхаа үр дүнг цоо шинээр бичиж байгаа мэт танилцуулах, дахин хэвлүүлэхийг хэлнэ. Үүнд дараах тохиолдлууд багтана.

- Өмнө хийсэн бие даалт, эсээ зэргийг өөр хичээлийн гүйцэтгэл болгон танилцуулах
- Бүтээлийн жагсаалтаа хуурамчаар үйлдэж танилцуулах

4. Кибер-хулгай

Мэдээллийн технологи, интернэтийн орчинд үйлдэгддэг оюуны хулгайг хэлнэ. Үүнд дараах тохиолдлууд багтана.

~ МУИС-ийн оюутан ёс суртахуунаараа манлайлна ~

- Цахим шалгалтын үеэр мэдээлэл харилцааны аппликэйшн, программ ашиглаж хуулах
- Орчуулгын программын үр дүнг шууд хуулж ашиглан өөрийн юм шиг танилцуулах, дамжуулах
- Интернэтээс бусдын хийсэн судалгааны үр дүнг олж өөрийн юм шиг танилцуулах, дамжуулах

ОЮУНЫ ХУЛГАЙ ЯМАР ХОХИРОЛ УЧРУУЛДАГ ВЭ?

Эрдэм шинжилгээний хүрээнд:

1. Шинэ мэдлэг бүтээдэггүй.
2. Бүтээлийн үнэ цэн, ач холбогдлыг бууруулна.
3. Бүтээлийн халдашгүй байх эрхийг зөрчинө.
4. Бүтээлд итгэх итгэл буурна.
5. Бүтээгчийн амины болон эд хөрөнгийн эрхийг зөрчинө.
6. Судлаачдыг төөрөгдөлд оруулна.
7. Зохиогчдын нэр хүндэд халдана.
8. Судлаачдын дунд үл ойлголцол үүсгэнэ.

Хуулагчийн хүрээнд:

1. Бүтээлч сэтгэлгээгүй болно.
2. Эрдэм шинжилгээний ёс зүйгүй болно.
3. Бусдын итгэл даах чадваргүй болно.
4. Өөрөө эвгүй байдалд орж, нэр хүндгүй болно.

ОЮУНЫ ХУЛГАЙГААС СЭРГИЙЛЭХ АРГУУД

1. Бусдын оруулсан хувь нэмрийг ямагт хүлээн зөвшөөрч, дурдах
2. Ашигласан бүтээлүүдээ эшлэх, ном зүйд нэгтгэн жагсаах
3. Ямар нэг баримт, мэдлэгт эргэлзэж буй бол эшлэл зүүлтэд ялган тодорхойлж, тайлбарлах
4. Бусдын санаа бодлыг бичгийн ажилдаа үг бүрчлэн ашиглах гэж байгаа бол хашилт (“...”)-д шууд эшлэх
5. Өөрөө хийж бүтээх дадал зуршил бий болгох

ОЮУНЫ ХУЛГАЙ, ХУУЛАЛТТАЙ ХОЛБОГДОХ

МУИС-ИЙН ДҮРЭМ, ЖУРАМ

Оюуны хулгай нь ёс зүйн ноцтой зөрчил бөгөөд бусдын санаа, үг өгүүлбэрийг өөрийн мэт ашиглан, тэдгээрт зохих эшлэл зүүлт хийхгүй байх, бусдын бүтээлийг зөвшөөрөлгүй ашиглах хэлбэрээр хийгддэг гэмт хэрэг юм.

МУИС нь оюуны хулгай хийх, хуулах үйлдлийг ёс зүйгүй үзэгдэл хэмээн үзэж, өөртөө харьяалагддаг бүх гишүүдээ дэмжихгүй байхыг уриалж, албан ёсоор дүрэмдээ тусган, үзэл баримтлалаа болгож байна. МУИС-д дараах дүрэм, журмаар оюуны хулгайтай холбоотой харилцааг зохицуулдаг:

- МУИС-ийн дүрэм
- МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм
- МУИС-ийн оюуны өмчийн талаар баримтлах бодлого
- МУИС-ийн сургалтын үйл ажиллагааны журам
- МУИС-ийн магистр, докторын судалгааны ажлын үр дүнг хүлээлгэн өгөх журам

МУИС-ийн дүрмээс

1.5. МУИС-ийн үйл ажиллагаанд дараах үндсэн зарчмыг баримтална:

1.5.5. Хариуцлагатай, ёс зүйтэй байх.

5.10. Багш холбогдох хууль тогтоомжид заасан үүрэг хүлээхээс гадна:

5.10.2. Хамт ажиллагчид болон суралцагчидтай хүндэтгэлтэй, шударга, ёс зүйтэй хандах

5.10.3. МУИС-ийн сургалт, судалгааны хүч хөрөнгөөр бий болсон оюуны бүтээлийг бусдад зүй бусаар ашиглуулахгүй байх үүрэгтэй.

6.6. Суралцагч холбогдох хууль тогтоомжид заасан үүрэг хүлээхээс гадна:

6.6.5. МУИС-ийн хүрээнд ёс зүй, эерэг зан үйлийг чандлан сахих, эрдмийн нэр хүндийг хүндэтгэх үүрэгтэй.

6.7. МУИС-ийн дүрэм журмыг зөрчсөн нь тогтоогдсон суралцагчийг сануулах, сургуулиас хасахаар сануулах, сургуулиас хасах арга хэмжээг бүрэлдэхүүн сургуулийн захирлын саналыг үндэслэн МУИС-ийн захирал шийдвэрлэнэ.

МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрмээс

2.2. Багшийн дагаж мөрдөх хэм хэмжээний судалгааны ажлын хүрээнд хуулах үзэгдлийг зохисгүй үйлдэл гэж үзэн хориглодог. Тухайлбал:

91. Бусдын бүтээл, санааг хулгайлах, эшлэлгүй ашиглах, хуулбарлах, зохиогчийн зөвшөөрөлгүй ашиглах;

92. Бусдын бүтээлийг өөрийн болгож илэрхийлэх;

2.4. Суралцагчийн дагаж мөрдөх хэм хэмжээний хүрээнд дараах үйлдлийг хуулах үзэгдэл хэмээн үзэж, хориглодог. Үүнд:

165. Бие даан гүйцэтгэхээр заасан лабораторийн ажил, дадлага, судалгааны ажил, хичээлийн бие даалт гүйцэтгэхдээ бусдаар хийлгэх, бусдын хийсэн зүйлийг хуулбарлах;

166. Лабораторийн ажил, судалгааны үр дүн бусад даалгаврыг хуурамчаар, зохиомлоор үйлдэх;

167. Хичээлийн даалгавар, бие даалтын ажил гүйцэтгэхдээ бусдын хийсэн ажил, дэвшүүлсэн санааг өөрийн болгож хууран мэхлэх. Үүнд, дараах тохиолдолд хууран мэхэлсэн гэж үзнэ:

167.1. Бусдын бүтээлийг хуулсан;

167.2. Өөр үгээр илэрхийлсэн боловч утга санаа нь хэвээр хадгалагдсан;

167.3. Бусдын санааг зөвшөөрөлгүй, зүй бусаар ашигласан;

168. Нэг хичээлийн даалгаврын гүйцэтгэлд шалгуулж үнэлгээ авсан ажлыг өөр хичээлийн даалгаварт шалгуулж, давхар үнэлүүлэх;

173. Сургалтын материалыг бусдаас хулгайлах, нуун дарагдуулах, өөрчлөх;

МУИС-ийн сургалтын үйл ажиллагааны журмаас

4.5.41. Шалгалтын дэг журам (бусдаас хуулах, бусдыг өөрийн нэрээр шалгалтад оруулах, зөвшөөрөгдөөгүй ном, дэвтэр ашиглах зэрэг) зөрчсөн суралцагчийн шалгалтын материалыг шалгагч багш хураан авч, тэмдэглэл хөтлөн, “F” дүн тавьж, ёс суртахууны зөрчил гаргасанд тооцож, уг зөрчил давтагдвал Бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөлийн хурал (МУИС-ийн ёс зүйн хороо)-аар хэлэлцэж, шийдвэр гаргана.

**МУИС-ийн магистр, докторын судалгааны ажлын үр дүнг
хүлээлгэн өгөх журмаас**

2.2. Суралцагч нь судалгааны ажил бичихдээ хуурамч мэдээлэл оруулаагүй, судалгааны үр дүнг хуулбарлаагүй, үнэн зөв, хууль эрхийн хүрээнд хийсэн эсэхээ хянаж, эрдмийн ёс зүйтэй, зохиогчийн эрхийг хамгаалж, бусдын хийсэн судалгааны үр дүнг эшилсэн байна.

3.8. Судалгааны ажилд эшлэл авахдаа АРА (American Psychological Association) хэв маягийг баримтална. Загвар 4-т заасан зааврын дагуу эшлэлийн бичиглэлийг боловсруулна.

4.14. Ном зүй: Судалгааны ажилд эшлэгдсэн бүтээлүүдийг жагсаалт хэлбэрээр харуулна.

4.14.1. Судалгааны ажилд эшлэгдсэн нэг сэдэвт бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл, номын бүлэг, цахим эх сурвалжийг бичнэ.

4.14.2. Судалгааны ажлын эшлэлийг АРА стандартаар бичнэ. Уг стандартаар бүтээлийн төрөл тус бүрээр ном зүйг бичих зааврыг (Хавсралт 3)-г харуулав.

4.16. Зохиогчийн эрхийн нотолгоо: Горилогчийн зүгээс судалгааны ажлыг өөрөө хийсэн болох, Монгол Улсын зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд заасны дагуу бусдын оюуны өмчийг зөрчөөгүй болохоо нотолж, баталгааны хуудас бичин гарын үсэг зурж хавсаргасан байна.

5.1. Суралцагчийг жинхэнэ хамгаалалтад орохыг зөвшөөрсөн удирдагчийн тодорхойлолтод үндэслэн номын сангаас тухайн судалгааны ажлыг “Бүтээлийн хуулбарлалтыг илрүүлэх систем”-ээр шалгасан тухай бичиг олгоно.

5.3. Бүтээлийн хуулбарлалт хийгдсэн гэж тодорхойлогдсон тохиолдолд суралцагч нь жинхэнэ хамгаалалтаас өмнө дахин нэг удаа шалгуулна.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ БИЧИХ СТАНДАРТЫН

ЗАРИМ ЖИШЭЭ

Эрдэм шинжилгээний ажлын стандартын дагуу бичих нь оюуны хулгайгаас сэргийлэх үр дүнтэй арга юм. Олон улсад эрдэм шинжилгээний ажил бичих олон стандарт баримталдаг. Тэдгээрээс Хүмүүнлэг, Нийгмийн ухааны салбарт түгээмэл баримталдаг стандарт нь АРА (American Psychological Association) хэв маяг юм уу, MLA (Modern Language Association) хэв маяг юм. Эдгээр стандартын тухай дэлгэрэнгүй мэдээллийг www.apastyle.apa.org, www.style.mla.org зэрэг вэбсайтаас авч болно.

Эрдэм шинжилгээний ажил бичих стандартын дагуу нэг бол шууд эшлэл авч, үгүй бол бичвэр дотор зүүлт, номзүйд эшлэлийг зааж жагсаан бичдэг.

Шууд эшлэл (quotation)

Зохиогчийн санааг шууд эшлэн авч (эшлэл нь 40-өөс доош үгтэй) өөрийн үгийг оролцуулан буулгасан бол эшилж авсан хэсэг, санаа, нэр томъёог “ ” хашилтад хийж өөрийн бичвэрээс зааглана.

Жишээ нь:

Орчин үеийн судлаачид нийгмийн үйл ажиллагааны хамгийн чухал хэрэгцээ болж байгаа зүйл бол ёс суртахууны үнэт зүйлс мөн болохыг тэмдэглээд тэр дундаа “бусдыг хүлээн зөвшөөрөх, ялгаатай байдлыг ойлгох, хүндлэл, бүтээлч байдал, нийгмийн сайн сайхны төлөөх үйл ажиллагаа” (Ашид М., 2018, 15) зэргийг илүүтэй чухалчилж байна.

Шууд эшлэл нь 40-өөс дээш үгтэй бол хашилтад хийхгүй бөгөөд эшилсэн хэсгийг бүхэлд нь зүүн гар талаас догол мөр үүсгэн тусгайлан бичнэ.

Жишээ нь:

...хэмээн М.Ашид зэрэг судлаачид үзжээ (Ашид, 2018, 22):

Утилитаризм хэмээх нэр томъёо нь латин хэлний utilitas буюу ашиг тус гэсэн утгатай үгнээс гаралтай. Ашиг тус ба хувь хүний ёс суртахууны сонголтын тухай асуудлыг чухалчилж, олон хүнд их аз жаргал эдлүүлэхийг эрмэлзэх ёстой хэмээн үздэг ёс зүйн баримтлал юм. Хамгийн олон тооны хүнд хамгийн их аз жаргал өгч чадах нийгмийн байгууламж бол хамгийн шилдэг сайн байх гэдэг нь утилитарист шударга ёсны үндсэн зарчим юм. Хувь хүний эдэлж байгаа жаргал ба зовлон зүдгүүрийн нийлбэрээс нийгмийн бүх гишүүдийн нийтдээ эдэлж байгаа жаргал ба зовлон зүдгүүрийн нийлбэрт шилжих явдал юм. Үүний агуулга нь би ямар ч үйлдэл хийлээ гэсэн миний энэ үйлдэл бусад хүний амьдралд тусах үр дагавар зайлшгүй авчирдаг төдийгүй бүх хүн аз жаргалд хүрнэ гэдэг бол тэгш боломж, тэгш эрхээс таашаал авахын нэр хэмээдэг.

Бичвэр дотор зүүлтэд эшлэх (citation)

Шууд эшилж бичиж болохоос гадна мөн бичвэр дотор зүүлтэд зааж эш татаж бичиж болно. Мөн зүүлтийг үгийн тайлбар, засвар, залруулга, нэмж судлах материалуудын талаарх мэдээллийг дэлгэрэнгүй өгөх зэрэг тохиолдолд хэрэглэж болно. Мөн дам эшилсэн тохиолдолд болон баримт мэдээллийг албан бус мэдээллээс (хүний яриа г.м) авсан бол тухайн баримт мэдээллийн анхдагч эх сурвалжийг олж тайлбарт бичиж болно.

Жишээ нь:

Нэгэн сэдэвт бүтээл

(Нэг зохиогчтой)

- Ч.Далай. (2002). *Ойрад Монголын түүх*. Боть 1. Улаанбаатар: Адмон, 288-294.

(Хоёр зохиогчтой)

- О.Бямбажав, Д.Дашдовдон. (1978). *Д.Сүхбаатарын нэрэмжит монголын пионерийн байгууллага*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 15-18.

(Гурав болон түүнээс дээш зохиогчтой)

- Ж.Болдбаатар нар. (2010). *Монгол улсын түүх*. Улаанбаатар: Соёмбо, 15-18.

Эмхэтгэл, түүвэр

- Ш.Чоймаа. (2007). “Чингис хааны бие хүний онцлог”, ред. У.Б.Баркманн. *Чингис хаан хийгээд түүний өв*. Улаанбаатар: Адмон, 16-30.

Эрдэм шинжилгээний өгүүлэл

- Б.Батсүрэн. (2010). “Хүннү, Тоба нэрийн тухай санал”, *Түүхийн судлал* 40, 41.

Олон нийтийн сонин, сэтгүүлийн нийтлэл

- Ч.Болортуяа. (2014/11/3). “Миний мэдэхгүй “тоглоом””, *Өнөөдөр* 255 (5349), А хэсэг, 4.

Ном зүй (reference)

Эх сурвалжаас их, бага ямар ч хэмжээний мэдээллийг шууд эш татсан, бусдын санааг хураангуйлан буулгаж бичсэн, бусдын санааг өөрийн үгээр буулгасан зэрэг бүх тохиолдолд эх сурвалжийг бичвэр дотор эш татсан тухайн газар нь заах төдийгүй ном зүйн жагсаалтад оруулна. Ном зүй нь бие даалт болон бусад бүтээлд ашигласан эх сурвалжийн талаар

мэдээллийг тогтсон загварын дагуу цагаан толгойн үсгийн дарааллаар жагсаасан жагсаалт юм. Уг жагсаалтыг судалгааны ажлын төгсгөлд оруулна. Ном зүй нь тухайн ажилд ямар эх сурвалж, баримт хэрэглэснийг илэрхийлэн харуулдаг төдийгүй тухайн бүтээлийг уншиж танилцаж байгаа хүнд эх сурвалжийг магадлах эсвэл цааш сонирхон судлах замыг нээж өгдөг мэдээллийн чухал хэсэг юм.

Жишээ нь:

Нэгэн сэдэвт бүтээл

(Нэг зохиогчтой)

- Далай Ч. (2002). *Ойрад Монголын түүх*. Боть 1. Улаанбаатар: Адмон.
- Leff, Gordon. (1969). *History and Social Theory*. London: Merlin Press.

(Хоёр зохиогчтой)

- Бямбажав О., Дашдовдон Д. (1978). *Д.Сүхбаатарын нэрэмжит монголын пионерийн байгууллага*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Fogel, R.W. and Elton, G.R. (1983). *Which Road to the Past: Two Views of History*. New Haven and London: Yale University Press.

(Гурав болон түүнээс дээш зохиогчтой)

- Бямбажав О. нар. (1978). *Д.Сүхбаатарын нэрэмжит монголын пионерийн байгууллага*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Jones, Mary et al. (2000). *A History of the World*. Bellingham: Beginning Press.

Эмхэтгэл, түүвэр

- Чоймаа Ш. (2007). “Чингис хааны бие хүний онцлог”, У.Б.Баркманн. (ред.). *Чингис хаан хийгээд түүний өв*. Улаанбаатар: Адмон, 16-20.
- Jackson, P. (2005). The Mongols and the Faith of the Conquered. In Reuven Amitai and Michal Biran. (eds.). *Mongols, Turks and Others. Eurasian Nomads and the Sedentary World*. Leiden and Boston: Brill, 20-28.

Эрдэм шинжилгээний өгүүлэл

- Батсүрэн Б. (2010). “Хүннү, Тоба нэрийн тухай санал”, *Түүхийн судлал* 40, 41-57.
- Cleaves, F. W. (1950). “The Sino-Mongolian Inscription of 1335 in Memory of Chang Ying-Jui.” *Harvard Journal of Asiatic Studies* 13/1-2, 1-131.